



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЗААВАР



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 12-ны өдрийн А/566 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлага гэдэг нь тухайн байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг **арилгах**, бууруулах, **шилжүүлэх** нэгэнт аюул осол, эрсдэл нүүрлэсэн тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах, ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдлээс ангид байх цогц үйл ажиллагаа.

Эрсдлийн удирдлага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн **тасралтгүй үргэлжлэх үйл явц** юм.



Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

1. Эрсдэлийг илрүүлж, нөхцөл байдлыг тодорхойлох

2. Эрсдэлийг тодорхойлох

3. Эрсдэлийг үнэлэх/эрэмблэх/

4. Эрсдэлд хариу арга хэмжээ авах



Эрсдэлийг илрүүлж, нөхцөл байдлыг тодорхойлох



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

1. Өдөр тутмын үйл ажиллагааны явцад дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс үүсч болох эрсдэлийн хүчин зүйлс, тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг тохиолдол мэдээлэх хуудас, үйл ажиллагааны явцын хяналт, аюулгүй байдлын тойрон үзлэг, албан ба албан бус мэдээлэл, санал, гомдолд тулгуурлан тогтооно.
2. Мөн өмнөх туршлага, мэргэжлийн хяналт болон аудитын дүгнэлт, олон давталттай тохиолдолд хийсэн дүгнэлт, ноцтой алдааны бүртгэл, эмгэг судлалын тэмдэглэл, чанарын үзүүлэлт зэрэг нотолгоонд тулгуурласан аргуудыг ашиглана.

Шинжилгээний аргууд /байгууллагын зорилго, орц, үйл ажиллагаа, харилцан хамаарал, гадаад ба дотоод нөлөөлөл/

- Байгууллагын үндсэн зорилгод нийцээгүй
- Байгууллагад хийгдсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүн
- Мэргэжлийн байгууллагын анхааруулга
- Ханган нийлүүлэгч байгууллагын анхааруулга
- Хүний нөөц, мэргэшсэн байдал
- Ёс зүйн асуудал
- SWOT анализ

Эрсдэлийг тодорхойлох



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Цуглуулсан баримт мэдээлэл дээр үндэслэн эрсдэлт хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж, ямар эрсдэл ямар хугацаанд ямар давтамжтайгаар тохиолдох магадлалтай түүнээс ямар үр дагавар үүсч болохыг тодорхойлно.

Тохиолдох магадлалаар

- Маш ховор
- Ховор
- Магадлалтай
- Тодорхой
- Өндөр магадлалтай

Үр дагавараар

- Хор хөнөөлгүй
- Бага зэрэг
- Дунд зэрэг
- Их
- Ноцтой

Эрсдэлийг тодорхойлох



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Магадлал		Бүртгэгдсэн давтамжийн тоо	
Зэрэглэл	Ангилал	Эмнэлзүйн эрсдэл	Гадаад, дотоод орчны эрсдэл
1	Маш ховор	3 буюу түүнээс дээш жилд 1 удаа	10-аас дээш жилд 1 удаа
2	Ховор	Жилд 1 удаа	5-10 жилд 1 удаа
3	Магадлалтай	Сард 1 удаа	3-5 жилд 1 удаа
4	Өндөр магадлалтай	7 хоногт 1 удаа	1-3 жилд 1 удаа
5	Тодорхой	Өдөрт 1 удаа	Жилд 1-ээс олон удаа

Эрсдэлийг тодорхойлох



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Үр дагавар		
1	Хор нөлөөгүй	Хувь хүн, байгууллагын нэр хүнд, барилга байгууламж, байгаль орчин, санхүүгийн ямар нэг нөлөөгүй, холбогдох хууль, журам тогтвортой
2	Бага зэрэг	Хувь хүн, байгууллагын нэр хүнд, барилга байгууламж, байгаль орчин, санхүүгийн хор нөлөө багатай, холбогдох хууль, журамд багахан өөрчлөлт орох, хүлээгдэл чирэгдэл үүсэх
3	Дунд зэрэг	Эмчилгээ шаардлагатай, байгаль орчинд дунд зэргийн үр дагавартай, санхүүгийн алдагдалтай, холбогдох хууль, журамд нэлээн өөрчлөлт орох, түр хугацааны хөдөлмөрийн чадвар алдалт, эмчилгээ үйлчилгээ түр хугацаагаар тасалдах
4	Их	Хувь хүн, байгууллагын нэр хүнд, барилга байгууламж, санхүүгийн хор нөлөө ихтэй, холбогдох хууль, журамд багахан өөрчлөлт орж шинэчлэгдсэн, удаан хугацааны хөдөлмөрийн чадвар алдалт, эмчилгээ, үйлчилгээ удаан хугацаагаар тасалдах
5	Ноцтой	Нас баралт, хүнд гэмтэл, байгаль орчинд аюултай үр дагавар, санхүүгийн асар их алдагдал, холбогдох хууль, журам хүчингүй болсон, байнга өөрчлөгдөж байдаг, үйл ажиллагаа зогсох

Эрсдэлийг үнэлэх/эрэмблэх/



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



- Эрсдэлийн түвшинг тоон утгаар тогтооно.
- Эрсдэлийг түвшинг тоон утгаар илэрхийлэгч үндсэн гол хэмжүүр нь магадлал болон үр дагавар юм. Магадлал нь үзэгдэх давтамжаар, харин үр дагаварыг үзүүлэх нөлөөлөл, хохиролоор хэмжинэ.

Магадлал x Үр дагавар = Эрсдэлийн зэрэг

- Эрсдэлийн үнэлгээний матрицыг ашиглана.

Эрсдэлийн үнэлгээний матриц



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Магадлал	Үр дагавар				
	Хор хөнөөлгүй	Бага хор хөнөөлтэй	Дунд хор хөнөөлтэй	Их хор хөнөөлтэй	Ноцтой хор хөнөөлтэй
Ховор	1	2	3	4	5
Магадлал багатай	2	4	6	8	10
Магадлалтай	3	6	9	12	15
Өндөр магадлалтай	4	8	12	16	20
Тодорхой	5	10	15	20	25

Эрсдэлийн үнэлгээний матриц



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Эрсдэлийн шинжилгээний матрицад эрсдэлийн зэргийг харгалзах тоонд тохируулан ногоон, хув, улаан өнгөөр тодотгосон байна.

Бага зэрэг - Ногоон өнгө нь тохиромжтой түвшин буюу эрсдэлд тохирсон зохицуулгын механизм байгааг илтгэнэ.

Дунд зэрэг - Хув өнгө нь тохиромжгүй түвшин буюу эрсдэлийг удирдахад тохиромжгүй байгааг илтгэнэ.

Их зэрэг - Улбар шар өнгө нь одоо ашиглаж байгаа зохицуулгын механизмд дутагдал, сул талтай, анхаарч өөрчлөх шаардлагатайг илтгэнэ.

Ноцтой – Улаан өнгө нь одоо ашиглаж байгаа зохицуулгын механизмд ноцтой дутагдал, сул талтай, хяналтгүй эрсдэл байгааг илтгэнэ.

Эрсдэлд хариу арга хэмжээ авах



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Эрсдэлд хариу арга хэмжээ 4 үндсэн аргыг ашиглана.

- **Эрсдэлийг арилгах** – Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэл учруулах үйл ажиллагааг зогсоох, эрсдлээс зайлсхийх тодорхой арга зам нэвтрүүлэх замаар эрсдэлийг арилгана.
- **Эрсдэлийг бууруулах, багасгах** - Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулна.
- **Эрсдэлийг шилжүүлэх** - Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэлээ даатгуулах юм уу өөр арга зам ашиглах замаар /байгууллага хэсэг бүлэг хүн/-д шилжүүлдэг.
- **Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх** - Эрсдэлээс үүдэн гарах хохирол, алдагдлыг тухайн эрүүл мэндийн байгууллага өөрөө хариуцна гэж үзэн тодорхой эрсдэлийг хүлээн зөвшөөрдөг. Ихэвчлэн давтамж, хохирлын хэмжээ багатай эрсдэлийг хүлээн зөвшөөрдөг.

Эрсдэлийг хариу арга хэмжээг авахдаа эрсдэлийн зэргийн хүснэгт ашиглана.

Эрсдэлийн баг нь эрсдэлд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулан удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлнэ.

Эрсдэлд хариу арга хэмжээ авах, эргэн хяналт



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

Зэрэглэл	Ангилал	Харгалзах өнгө	Зохион байгуулах үйл ажиллагаа	Шийдвэрлэлт	Эргэн хяналт
1-3	Бага	Ногоон	Тэвчиж болохуйц эрсдэл	Нэгжийн түвшинд зэрэглэл бууруулах үйл ажиллагаа зохион байгуулна.	Жилд 1 удаа эргэн хянана.
4-6	Дунд	Шар	Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргана	Чанарын албанд мэдэгдэж нэгжийн түвшинд авах арга хэмжээг тогтооно.	Улирал тутам, хагас жилд эргэж хянана
7-12	Их	Улбар шар	Үйл ажиллагааны төлөвлөгөө яаралтай шаардлагатай	Байгууллагын удирдлагад мэдэгдэж авах арга хэмжээг тогтооно.	Хагас жил, жилд эргэн хянана. Гүйцэтгэлийн хяналт хийнэ.
13-25	Ноцтой	Улаан	Даруй арга хэмжээ шаардлагатай	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ. Ажлын хэсэг томилон арга хэмжээ авна.	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд хяналт тогтмол хийнэ.

Эрсдэлийг мэдээлэх



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



1. **1-6 хүртлэх** оноогоор үнэлэгдсэн бага, дунд зэргийн эрсдэлийг байгууллагын түвшинд зохицуулан шийдвэрлэнэ.
2. **7-12 хүртлэх** оноогоор үнэлэгдсэн их эрсдэлийг сум, тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төв, хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төв, амаржих газар, сувилахуйн төв, нэгдсэн эмнэлэг, сувилал, клиник, түргэн тусламжийн төв, сэргээн засах төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь улирал тутам харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрсдэлийн санд мэдээлнэ.
3. **Аль ч түвшний эрүүл мэндийн байгууллага 13–25 хүртлэх** оноогоор үнэлэгдсэн ноцтой эрсдэлийг шууд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрсдэлийн санд мэдээлнэ.

Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын эрсдэл хариуцсан баг, чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан хэлтэс өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудаас илгээсэн эрсдэлийг эрэмбэлж хамгийн ноцтой, их ангилалд хамаарахаас нь эхлэн холбогдох байгууллагуудтай хамтран **эрсдэлийг арилгах, бууруулах, шилжүүлэх** арга хэмжээ авна.

Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хариу арга хэмжээ үзүүлэхээр шийдвэрлэсэн бол Эрүүл мэндийн хөгжлийн төв /Эрсдэлийн мэдээний сан/-д нэн даруй мэдээлнэ.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia

АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА